

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/072/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум	Ахлах аудитор : Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
2026 он	Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛИЙН
ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
Д.ЗАГДГОЧОО ТАНАА

2026.02.25 № СГА-2026/042/МА-СГА-ТЦС

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/246 дугаар тушаалаар "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагаанд гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг олгоход баримтлах аргачлал"-ыг баталсан байна. Тайлант онд багш, ажилтнуудын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнд үнэлгээ хийж, 70 онооноос дээш үнэлэгдсэн 52 албан хаагчид нийт 75,716.4 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг БШУЯ-аас 2021 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллежийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 99.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	105,564,379.36	357,153,272.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		105,564,379.36	357,153,272.18
3121	Төгрөг		105,564,379.36	357,153,272.18
31211	Төрийн сангийн харилцах		105,564,379.36	357,153,272.18
33	АВЛАГА	5	13,140,000.00	
335	Бусад авлага		13,140,000.00	
3351	Байгууллагаас авах авлага		13,140,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	6	446,481,297.57	485,742,420.09
351	Түүхий эд материал		134,591,526.47	134,591,526.47
3511	Тусгай зориулалттай материал		134,131,826.47	134,131,826.47
3513	Эм боох материал		459,700.00	459,700.00
353	Бэлэн бүтээгдэхүүн		883,180.00	1,723,180.00
354	Хангамжийн материал		303,746,591.10	342,007,713.62
3541	Бичиг хэргийн материал		14,540,000.00	11,798,979.00
3542	Аж ахуйн материал		58,469,803.50	43,307,532.00
3544	Түлш, шатах тослох материал		6,031,754.50	40,778,054.50
3545	Барилгын засварын материал		23,846,214.78	15,272,464.80
3546	Хүнсний материал		4,209,240.00	7,173,270.00
3547	Бусад хангамжийн материал		196,649,578.32	223,677,413.32
355	Биологийн хөрөнгө		5,000,000.00	5,000,000.00
356	Мал амьтад		2,260,000.00	2,420,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА			2,000,000.00
363	Тэжээлийн нөөц			2,000,000.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		565,185,676.93	844,895,692.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	6,036,022,458.64	5,845,733,914.97
392	Биет хөрөнгө		5,123,179,958.64	4,931,715,789.98
39201	Барилга, байгууламж, орон сууц		6,097,000,525.84	6,227,163,245.84
39202	Хуримтлагдсан элэгдэл		(1,731,615,745.67)	(2,017,080,461.15)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		198,851,918.25	198,851,918.25
39204	Хуримтлагдсан элэгдэл		(179,590,737.96)	(187,953,804.81)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		1,262,084,189.80	1,351,425,689.80
39206	Хуримтлагдсан элэгдэл		(844,109,751.38)	(976,158,421.91)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		305,841,494.55	328,318,494.55
39208	Хуримтлагдсан элэгдэл		(136,830,012.56)	(171,211,130.00)
39209	Зам, гүүрийн байгууламж		40,696,967.89	40,696,967.89
39210	Хуримтлагдсан элэгдэл		(14,678,824.16)	(16,928,941.52)
39217	Ном		125,529,934.04	154,592,233.04
393	Биет бус хөрөнгө		912,842,500.00	914,018,124.99
39301	Программ хангамж		22,593,000.00	24,323,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(21,700,500.00)	(22,254,875.01)
39303	Бусад биет бус хөрөнгө		911,950,000.00	911,950,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,036,022,458.64	5,845,733,914.97
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,601,208,135.57	6,690,629,607.24
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	668,500.00	592,518.00

413	Өглөг		668,500.00	592,518.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		668,500.00	
4136	Бусад өглөг			592,518.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг			592,518.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		668,500.00	592,518.00
51	Засгийн газрын хувь оролцоо		6,600,539,635.57	6,690,037,089.24
512	Хуримтлагдсан үр дүн		6,600,539,635.57	6,690,037,089.24
5121	Өмнөх үеийн үр дүн		6,600,539,635.57	6,600,539,635.57
5122	Тайлант үеийн үр дүн			89,497,453.67
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,600,539,635.57	6,690,037,089.24
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,601,208,135.57	6,690,629,607.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,007,109,086.33	4,232,912,536.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		3,236,219,300.00	3,342,872,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		3,236,219,300.00	3,342,872,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		24,132,617.00	33,828,036.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		24,132,617.00	33,828,036.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		746,757,169.33	856,211,700.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		746,757,169.33	856,211,700.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		6,823,241,602.41	36,987,699.00
120	Нийтлэг татварын бус орлого		6,823,241,602.41	36,987,699.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,485,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		2,485,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		6,417,683,495.84	30,272,299.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		403,073,106.57	6,715,400.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	10,830,350,688.74	4,269,900,235.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,220,937,099.17	4,180,402,781.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,912,260,816.17	4,110,438,781.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,148,152,610.62	2,333,583,895.65
210101	Үндсэн цалин		1,198,306,092.82	1,202,726,457.19
210102	Нэмэгдэл		677,568,152.63	852,781,058.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт		165,868,679.27	180,596,000.00
210104	Урамшуулал		106,409,685.90	97,480,380.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		269,105,360.10	291,801,312.36
210201	Тэтгэврийн даатгал		184,093,300.63	199,221,622.81
210202	Тэтгэмжийн даатгал		21,336,682.15	23,980,766.14
210203	ҮОМШӨ-ний даатгал		11,962,542.47	13,596,842.64
210204	Ажилгүйдлийн даатгал		10,341,767.07	10,974,390.06
210205	Эрүүл мэндийн даатгал		41,371,067.78	44,027,690.71

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		588,850,669.33	619,290,800.20
210301	Гэрэл, цахилгаан		52,814,417.13	68,217,388.80
210302	Түлш, халаалт		517,780,652.20	530,398,361.40
210303	Цэвэр, бохир ус		18,255,600.00	20,675,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал		39,694,751.92	47,586,318.37
210401	Бичиг хэрэг		2,672,650.00	4,482,860.00
210402	Тээвэр, шатахуун		20,047,800.00	471,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,745,041.92	3,172,599.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		7,652,060.00	39,459,358.50
210408	Бараа материал акалсны зардал		1,577,200.00	
2105	Нормативт зардал		85,080,130.00	88,840,858.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		747,100.00	376,000.00
210502	Хоол, хүнс		84,333,030.00	88,464,858.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		141,240,030.00	102,434,529.98
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		65,500.00	
210604	Урсгал засвар		141,174,530.00	102,434,529.98
2107	Томилолт, зочны зардал		25,461,000.00	5,600,000.00
210702	Дотоод албан томилолт		25,461,000.00	5,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж			34,890,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			34,890,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		614,676,264.20	586,411,066.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		20,379,065.00	42,664,081.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		47,036,062.00	80,684,923.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		547,261,137.20	463,062,062.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		308,676,283.00	69,964,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		308,676,283.00	69,964,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		184,940,283.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		111,392,000.00	68,964,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		12,344,000.00	1,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	4,220,937,099.17	4,180,402,781.53
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		6,609,413,589.57	89,497,453.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		8,915,000.00	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		7,275,000.00	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		1,640,000.00	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(8,915,000.00)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		6,600,498,589.57	89,497,453.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,009,594,086.33	4,232,449,811.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,485,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	2,485,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,485,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,007,109,086.33	4,232,449,811.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,236,219,300.00	3,342,872,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,236,219,300.00	3,342,872,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,132,617.00	33,365,311.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,132,617.00	33,365,311.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	746,757,169.33	856,211,700.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	746,757,169.33	856,211,700.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,904,029,706.97	3,750,792,216.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,904,029,706.97	3,750,792,216.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,595,353,423.97	3,680,828,216.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,147,484,110.61	2,333,789,670.65
210101	Үндсэн цалин	1,197,637,592.82	1,202,932,232.19
210102	Нэмэгдэл	677,568,152.63	852,781,058.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	165,868,679.27	180,596,000.00
210104	Урамшуулал	106,409,685.89	97,480,380.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	269,064,314.11	291,801,312.36
210201	Тэтгэврийн даатгал	184,052,254.63	199,221,622.81
210202	Тэтгэмжийн даатгал	21,336,682.15	23,980,766.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,962,542.47	13,596,842.64
210204	Ажилгүйдлийн даатгал	10,341,767.08	10,974,390.06
210205	Эрүүл мэндийн даатгал	41,371,067.78	44,027,690.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	586,556,069.33	654,037,100.20
210301	Гэрэл, цахилгаан	52,814,417.13	68,217,388.80
210302	Түлш, халаалт	515,486,052.20	565,144,661.40
210303	Цэвэр, бохир ус	18,255,600.00	20,675,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал		7,655,819.87
210401	Бичиг хэрэг		4,013,220.00
210402	Тээвэр, шатахуун		470,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,172,599.87
2105	Нормативт зардал	92,708,000.00	101,424,334.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		376,000.00
210502	Хоол, хүнс	92,708,000.00	101,048,334.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	188,323,500.00	88,875,480.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,047,700.00	8,318,600.00
210604	Урсгал засвар	174,275,800.00	80,556,880.00
2107	Томилолт, зочны зардал		5,600,000.00
210702	Дотоод албан томилолт		5,600,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		47,401,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		47,401,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	311,217,429.92	150,242,899.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,513,629.92	83,088,213.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	167,703,800.00	67,154,686.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	308,676,283.00	69,964,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	308,676,283.00	69,964,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	184,940,283.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	111,392,000.00	68,964,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,344,000.00	1,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	105,564,379.36	481,657,594.82
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		230,661,220.00
	Дотоод эх үүсвэрээр		230,661,220.00
220001	Барилга байгууламж		130,162,720.00
222001	Тоног төхөөрөмж		85,601,500.00
223001	Бусад хөрөнгө		14,897,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(230,661,220.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	105,564,379.36	250,996,374.82
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		105,564,379.36
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		357,153,272.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Бусад цэвэр хөрөнгө/өмч	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		6,600,539,635.57	6,600,539,635.57
2	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
3	Тайлант үеийн үр дүн		90,004,993.10	90,004,993.10
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		6,600,539,635.57	6,600,539,635.57
5	Тайлант үеийн үр дүн		89,497,453.67	89,497,453.67
6	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		6,690,037,089.24	6,690,037,089.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,442,818,100.00	4,232,449,811.20	210,368,288.80	95.26
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,440,324,500.00	3,376,238,111.00	64,086,389.00	98.14
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,353,023,900.00	3,342,872,800.00	10,151,100.00	99.70
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	55,902,300.00		55,902,300.00	

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,398,300.00	33,365,311.00	(1,967,011.00)	106.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,398,300.00	33,365,311.00	(1,967,011.00)	106.26
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,002,493,600.00	856,211,700.20	146,281,899.80	85.41
132001	Орон нутгийн төсвөөс	1,002,493,600.00	856,211,700.20	146,281,899.80	85.41
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,442,818,100.00	4,232,449,811.20	210,368,288.80	95.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,442,818,100.00	3,750,792,216.38	692,025,883.62	84.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,372,854,100.00	3,680,828,216.38	692,025,883.62	84.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,501,054,400.00	2,333,789,670.65	167,264,729.35	93.31
210101	Үндсэн цалин	1,272,483,000.00	1,202,932,232.19	69,550,767.81	94.53
210102	Нэмэгдэл	1,055,441,100.00	852,781,058.46	202,660,041.54	80.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	173,130,300.00	180,596,000.00	(7,465,700.00)	104.31
210104	Урамшуулал		97,480,380.00	(97,480,380.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,995,900.00	291,801,312.36	26,194,587.64	91.76
210201	Тэтгэврийн даатгал	216,237,100.00	199,221,622.81	17,015,477.19	92.13
210202	Тэтгэмжийн даатгал	25,439,700.00	23,980,766.14	1,458,933.86	94.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,719,900.00	13,596,842.64	(876,942.64)	106.89
210204	Ажилгүйдлийн даатгал	12,719,900.00	10,974,390.06	1,745,509.94	86.28
210205	Эрүүл мэндийн даатгал	50,879,300.00	44,027,690.71	6,851,609.29	86.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	800,231,000.00	654,037,100.20	146,193,899.80	81.73
210301	Гэрэл, цахилгаан	114,904,800.00	68,217,388.80	46,687,411.20	59.37
210302	Түлш, халаалт	656,222,200.00	565,144,661.40	91,077,538.60	86.12
210303	Цэвэр, бохир ус	29,104,000.00	20,675,050.00	8,428,950.00	71.04
2104	Хангамж, бараа материалын зардал		7,655,819.87	(7,655,819.87)	
210401	Бичиг хэрэг		4,013,220.00	(4,013,220.00)	
210402	Тээвэр, шатахуун		470,000.00	(470,000.00)	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		3,172,599.87	(3,172,599.87)	
2105	Нормативт зардал	164,253,700.00	101,424,334.00	62,829,366.00	61.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		376,000.00	(376,000.00)	
210502	Хоол, хүнс	164,253,700.00	101,048,334.00	63,205,366.00	61.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	221,159,000.00	88,875,480.00	132,283,520.00	40.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,350,000.00		3,350,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,546,400.00	8,318,600.00	7,227,800.00	53.51
210604	Урсгал засвар	202,262,600.00	80,556,880.00	121,705,720.00	39.83
2107	Томилолт, зочны зардал		5,600,000.00	(5,600,000.00)	
210702	Дотоод албан томилолт		5,600,000.00	(5,600,000.00)	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,787,400.00	47,401,600.00	11,385,800.00	80.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,787,400.00	47,401,600.00	11,385,800.00	80.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,372,700.00	150,242,899.30	159,129,800.70	48.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,385,800.00	83,088,213.30	76,297,586.70	52.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	149,986,900.00	67,154,686.00	82,832,214.00	44.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,964,000.00	69,964,000.00		100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,964,000.00	69,964,000.00		100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	68,964,000.00	68,964,000.00		100.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00		100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		230,661,220.00	(230,661,220.00)	
	Дотоод эх үүсвэрээр		230,661,220.00	(230,661,220.00)	
220001	Барилга байгууламж		130,162,720.00	(130,162,720.00)	
222001	Тоног төхөөрөмж		85,601,500.00	(85,601,500.00)	
223001	Бусад хөрөнгө		14,897,000.00	(14,897,000.00)	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,442,818,100.00	3,981,453,436.38	461,364,663.62	89.62
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		105,564,379.36	(105,564,379.36)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		357,153,272.18	(357,153,272.18)	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.00
3	Төсвийн байгууллага	1	1		100.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
6	Удирдах ажилтан	3	3		100.00
7	Гүйцэтгэх ажилтан	37	33	4	89.19
8	Үйлчлэх ажилтан	30	30		100.00
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
31	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	70	66	4	94.29

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Политехникийн коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үндсэн хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

Политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн

нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,220,937.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 42,209.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус коллеж нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Хэвлэл захиалгын төлбөр гаргаагүй,*
- *Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 31 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад нийт **20,553.7** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Өмнөх оны ажлыг улирал бүр дүгнэж, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон атал захирлын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь өр, авлагагүй гаргаж, сахилга бат, ил тод байдлыг ханган ажилласан гэх үндэслэлээр нягтлан бодогч Т.Түвшинжаргалд 2, нярав Э.Азжаргал, Л.Отгонсүрэн нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу нийт 5,328.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон,
- Жилийн эцэст хэрэгцээнээсээ илүү 14,825.7 мянган төгрөгийн нүүрс нөөцөлсөн (*Тайлант оны 12 дугаар сард 130.2 тн нүүрс хэрэглэсэн бөгөөд нийт 227.1 тн нүүрсний үлдэгдлээс хасаж, 96.9 тн үлдэгдлээр тооцов*),
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас багш нарын баярт зориулсан спортын тэмцээний бооцоонд 400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага ... дараах зүйлийг хориглоно”, 15.1.3 дахь “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.6 дэх “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, 15.1.8 дахь “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Политехник коллеж нь мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн байна.

Тус коллежийн 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин хөлстэй холбоотой 2 зөрчилд тогтоосон төлбөрийн акт болон 1 зөрчилд өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	2,000.9	2	2,000.9	100.0
Албан шаардлага	1	51,620.0	1	51,620.0	100.0
Нийт дүн	3	53,620.9	3	53,620.9	100.0

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,160.0 мянган төгрөгийн дараах алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 1,210.0 мянган төгрөгөөр, бараа материалыг 950.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Дээрх алдаанууд нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3.4 дэх заалт болон УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулга-ын 99¹, “Ангилал” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт **157,851.1** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 37,980.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 119,870.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Нийт илрүүлсэн 37,980.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,229.1 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

4.1 Албан шаардлага

1. Улсын төсвийн санхүүжилтийн бараа үйлчилгээний зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 13,794.0 мянган төгрөгийг, орон нутгаас олгосон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,904.0 мянган төгрөг зэрэг нийт **15,698.0** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалт болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- Орон тооны цомхотголд орсон гэх үндэслэлээр байрны багшаар ажиллаж байсан Б.Бат-Эрдэнэд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 7,070.0 мянган төгрөгийн, Б.Отгонжаргалд бараа үйлчилгээний бусад зардлаас 4,242.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас захирал Д.Загдгочоод гадаад албан томилолтын зардал олгосон,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас портер машины сэлбэг авахад 887.0 мянган төгрөгийг, намираа шланг, холбогч авахад 400.5

¹ Санхүүгийн үр дүнгийн тайлан: УСНББОУС-д өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг ашиг, алдагдалд тусгана.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгийг, автомашины багаж хэрэгсэл авахад 616.5 мянган төгрөгийг зарцуулсан гэх мэт.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Анхан шатны баримт буюу гэрээ байгуулалгүйгээр дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас Силк роуд интернейшнл ХХК (*Номандс ресторан, зочид буудлын дансанд 3 удаагийн шилжүүлгээр*) -д 978.6 мянган төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гагнуурын сургагч багш Д.Бямбадоржийн сургалтын төлбөрт 750.0 мянган төгрөгийг Ченж энд вин ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 126 нэр төрлийн, 119,870.8 мянган төгрөгийн анхны үнэтэй хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь “... *элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “... *байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...*” гэсэн заалтууд болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

тайланг хүлээн авснаас хойш **30** хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй авсан хөрөнгө, бараа материалыг дутуу тайлагнасан.	1	2,160.0	1	2,160.0	-	-	1	2,160.0	-	-	-	-
Дүн	1	2,160.0	1	2,160.0	-	-	1	2,160.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	15,698.0	-	-	1	15,698.0	-	-	-	-	-	-
Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгасан.	1	1,728.6	-	-	1	1,728.6	-	-	-	-	-	-

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй.	1	119,870.8	-	-	-	-	1	119,870.8	-	-	-	-
Дүн	3	137,297.4	-	-	1	17,426.6	1	119,870.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хууль тогтоомжид заагдаагүй урамшуулал олгосон.	1	5,328.0	-	-	1	5,328.0		
Хэрэгцээнээсээ илүү нүүрс нөөцөлсөн.	1	14,825.7	-	-	1	14,825.7		
Багш нарын баярт зориулсан спортын тэмцээний бооцоонд шилжүүлсэн.	1	400.0	-	-	1	400.0		
Нийт дүн	3	20,553.7	-	-	3	20,553.7	-	-